



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/424


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Төсөв батлах тухай" 2018 оны 23/15 дугаар тогтоол, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 60 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/424 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/424 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд санхүүжих хот тохижилт, нийтийн аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын 3, 5, 16 дугаар ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж ажиллахыг Үнэлгээний хороо /Э.Энхцэцэг/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 12 сарын 10 өдрийн
114/199/17 тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга :	Э.Энхцэцэг	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга
Гишүүд :	Б.Түмэнбаяр	Нийслэлийн Мэдээлэл, Технологийн газрын Мэдээллийн сүлжээ, техник, хяналтын хэлтсийн дарга /зөвшилцсөнөөр/
	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн цахилгаан хангамж, гэрэлтүүлэг, холбооны асуудал хариуцсан Ахлах мэргэжилтэн
	Р.Дуламжав	Баянзүрх дүүргийн 25-р хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга :	С.Эрдэнэболд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн